

**ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ
ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЯВУУЛСАН ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 05 дугаар
сарын 19-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих, орлогын тэгш бус байдлыг бууруулах, дундаж давхаргыг тэлэх, иргэдийн бодит орлого болон худалдан авах чадварыг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зэрэг зорилтуудыг хэрэгжүүлэх шаардлагын хүрээнд татварын хөнгөлөлтийг эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан нэмэгдүүлэх, үйл ажиллагааны орлоготой иргэдэд хамаарах татварын хялбаршуулсан горимд олон улсын жишигт нийцсэн босго тогтоох, хувь хүн тодорхой хугацаанд өмчилсөн өөрийн орон сууцаа худалдан борлуулсан тохиолдолд үл хөдлөх эд хөрөнгийн борлуулалтын албан татвараас чөлөөлөх, түүнчлэн татварын тайлан тушаах болон төлөх хугацааг хойшлуулах зохицуулалтыг тусгаж хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар татварын ачааллыг бууруулж, бодит орлогыг нэмэгдүүлэн урт хугацаандаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эдийн засгийн идэвхжилийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн тогтвортой өсөлтийг дэмжих эерэг үр дагавартай гэж үзсэн байна.

Хуулийн төслийг d.parliament.mn цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн төсөвт үзүүлэх нөлөөллийг нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын дүнтэй харьцуулан тооцсон эсэх, мөн иргэдийн сарын 792 мянган төгрөг хүртэлх орлогод ногдуулах албан татварыг 100 хувь хөнгөлөхөд улсын төсвийн орлогын бууралтыг тооцсон эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 68.8 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Н.НАРАНБААТАР